



## НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААНД УРЬЖ БАЙНА

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн А-128 дугаар тушаалаар Хөвсгөл аймаг дахь Монголбанкны салбарт төлбөрт тооцон өгсөн үл хөдлөх хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэрлэв.

### Дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн танилцуулга:

**1 дүгээр багц.** Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 8 дугаар багийн 2 дугаар хэсэгт байрлалтай худалдаа, үйлчилгээний зориулалттай 1 давхар барилга, 2 давхар амины сууц, 2 автомашины гарааш, 1365 м.кв талбай бүхий эзэмших эрхийн газрын хамт



Барилгын нэр: Худалдаа, үйлчилгээний зориулалттай 1 давхар барилга  
Байршил: Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 8 дугаар багийн 2 дугаар хэсэг  
Эзэмшил газрын хэмжээ: 1365 м.кв  
Ашиглалтанд орсон он: 2006

Барилгын хэмжээ: доторх шалны талбай 5.3 x 11.3 м, 4.2 x 6.2 м  
Давхрын тоо: 1  
Талбайн хэмжээ: 86 м.кв

Хийц бүтээц: Шаамал ханатай, гадуур нь хавтангаар өнгөлсөн, бетонон суурьтай, модон хучилттай, төмөр дээвэртэй, хаалттай модон цонхтой, дан модон хаалгатай, дотор ханыг ислэг хавтангаар доторлосон, дүүжин таазтай, төвийн дулааны шугамд холбогдсон /одоогоор түр хаасан/ Одоогийн байдлаар ашиглаагүй, хоосон болно.

Барилгын нэр: 2 давхар амины сууц  
Байршил: Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 8 дугаар багийн 2 дугаар хэсэг  
Эзэмшил газрын хэмжээ: 1365 м.кв  
Ашиглалтанд орсон он: 2009

Барилгын хэмжээ: доторх шалны талбай 8.8 x 6.9 м  
Давхрын тоо: 2  
Талбайн хэмжээ: 122 м.кв

Хийц бүтээц: 1 дүгээр давхар нь дүнзэн ханатай, бетонон суурьтай, модон хучилттай, модон цонхтой, төмөр хаалгатай, ислэг хавтан таазтай, 2 дугаар давхар нь шаамал ханатай, төмөр дээвэртэй, модон цонхтой, төмөр хаалгатай, дотор ханыг модоор доторлосон, дүүжин таазтай. Төвийн дулааны шугам цэвэр, бохир усны төвлөрсөн сүлжээ, төвийн цахилгаан эрчим хүчинд тус тус холбогдсон. Одоогийн байдлаар худалдаа, үйлчилгээний зориулалттай 1 дүгээр

давхар хоосон, амины сууцны зориулалттай 2 дугаар давхар объектын харуул хамгаалалтыг хариуцаж хүн амьдарч байна.

Барилгын нэр: 2 автомашины гарааш

Байршил: Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 8 дугаар багийн 2 дугаар хэсэг

Эзэмшил газрын хэмжээ: 1365 м.кв

Ашиглалтанд орсон он: 2009

Барилгын хэмжээ: доторх шалны талбай 6.5 х 7 м

Талбайн хэмжээ: 45.5 м.кв

Хийц бүтээц: Дүнзэн ханатай, модон дээвэртэй, хар цаасан хучилттай, дээврээс ус гоождог, төмөр хаалгатай, 2 машин байрлах талбайтай, шал хийгээгүй, инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй.

Дээр дурдсан хөрөнгүүд нь банзан хашаатай, нүүрэн талдаа жижиг, том 2 хаалгатай. Том хаалга нь автомашин орох зориулалттай төмөр хийцтэй, жижиг хаалга нь хүн орох зориулалттай төмөр сараалжин хийцтэй болно.

Дулаан, цэвэр усны 1 худаг, бохир усны 1 худаг тус тус хашааны гадна, усны тоолуур нь 2 давхар барилгын 1 дүгээр давхарт тус тус байрлаж байна.

Хашааны гадна 1, дотор 1 ширхэг цахилгаан дамжуулах шугамын шон байрлаж байна. Цахилгааны тоолуур 2 давхар барилгад байрлаж байна.

**2 дугаар багц.** Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 11 дүгээр багийн 20 дугаар гудамжны 9 тоотод байрлалтай амины сууц, 664 м.кв талбай бүхий өмчлөх эрхийн газрын хамт



Барилгын нэр: Амины сууц

Байршил: 11 дүгээр багийн 20 дугаар гудамжны 9 тоот

Өмчилсөн газрын хэмжээ: 664 м.кв

Ашиглалтанд орсон он: 2003

Барилгын хэмжээ: гадна суурийн хэмжээ 6.5 х 8.3 м

Давхрын тоо: 1

Талбайн хэмжээ: 54 м.кв

Хийц бүтээц: Дүнзэн ханатай, бетонон суурьтай, модон хучилттай, модон дээвэртэй, дээвэр нь хар цаасан хучилттай, модон цонхтой, дан модон хаалгатай, дотор талын ханыг шавардаж будсан, ислэг хавтан таазтай, модон шалтай, ердийн галлагаатай, гудамж руугаа харсан хаалгатай, үүдэндээ модон тамбуртай. Одоогийн байдлаар ашиглаагүй, хоосон болно. Урд болон хойд талдаа модон хашаатай. Хүн орох зориулалт бүхий 1 жижиг төмөр хаалгатай.

Дуудлага худалдаа болох хугацаа

2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн  
11.00 цагт

Дуудлага худалдаа болох газар	Монголбанкны Төв байр
Санал болгох доод үнэ	<b>1 дүгээр багц.</b> Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 8 дугаар багийн 2 дугаар хэсэгт байрлалтай худалдаа, үйлчилгээний зориулалттай 1 давхар барилга, 2 давхар амины сууц, 2 автомашины гарааш, 1365 м.кв талбай бүхий эзэмших эрхийн газрын хамт 155,576,000.00 (нэг зуун тавин таван сая таван зуун далан зургаан мянган) төгрөг
	<b>2 дугаар багц.</b> Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 11 дүгээр багийн 20 дугаар гудамжны 9 тоотод байрлалтай амины сууц, 664 м.кв талбай бүхий өмчлөх эрхийн газрын хамт 17,312,000.00 (арван долоон сая гурван зуун арван хоёр мянган) төгрөг
Дуудлагын худалдаанд тавих дэнчингийн хэмжээ	<b>1 дүгээр багц.</b> Худалдах доод үнийн 20 хувь буюу 31,115,200.00 (гучин нэгэн сая нэг зуун арван таван мянга хоёр зуун) төгрөг
	<b>2 дугаар багц.</b> Худалдах доод үнийн 20 хувь буюу 3,462,400.00 (гурван сая дөрвөн зуун жаран хоёр мянга дөрвөн зуун) төгрөг
Худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөл	Худалдан авагч нь дуудлага худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийн үнийг 14 хоногийн дотор төлнө.
Дэнчинг байршуулах данс	Хүлээн авагч байгууллага: Монголбанк дансны дугаар: 4101000022 дансны нэр: бусад

### Дуудлагын худалдаанд хүсэлт ирүүлэх

1. Дуудлагын худалдаанд оролцох хүсэлтийг 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 11.00 цаг хүртэл Монголбанкны “А” байрны 1 дүгээр давхрын 2 тоот өрөөнд хүлээн авна. **Хугацаа хоцорсон хүсэлтийг хүлээн авах боломжгүйг анхаарна уу.**

2. Дуудлагын худалдаанд оролцох хүсэлт нь зөв, цэвэр бөглөсөн худалдаанд оролцох хүсэлтийн маягт, дэнчин төлснийг нотлох баримт, иргэний үнэмлэх (аж ахуйн нэгжийн хувьд улсын бүртгэлийн гэрчилгээ)-ний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар зэрэг баримтаас бүрдэнэ.

### Худалдах үл хөдлөх хөрөнгийн мэдээлэл авах

Худалдах барилгын талаарх мэдээлэл, дуудлагын худалдааны журам, худалдаанд оролцох хүсэлтийн маягтыг Монголбанкны [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn) цахим хуудас эсвэл Хөвсгөл аймаг дахь Монголбанкны салбараас авна уу. Дуудлага худалдаанд оролцохыг сонирхсон этгээд барилгатай танилцахыг хүсвэл Хөвсгөл аймаг дахь Монголбанкны салбар дээр очиж уулзана уу.

Лавлах утас: 310633,  
Хөвсгөл аймаг дахь Монголбанкны  
салбар 70382452, 70384023, 99033250

**МОНГОЛБАНК**